



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/11

Мөрөн сум

Үйл ажиллагааны үнэлгээг баталж,
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 31 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үнэлгээг нэгдүгээр хавсралтаар, шалгарсан сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын үйл ажиллагааны урамшуулалд олгох зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үнэлгээгээр тэргүүлсэн сумдын урамшуулалд олгох 7680000 (Долоон сая зургаан зуун наян мянган) төгрөгийг Засаг дарга ерөнхий данснаас гаргахыг аймгийн ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяад), шалгарсан сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын цалингийн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс зарцуулахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД